



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ

# 2019

6-Р САР

## Э-сонин

71-р дугаар






# Үнэт цаасны зах зээл

## Зах зээлийн тойм


/2019.06.30-ны өдрийн байдлаар/

|                                            |                |
|--------------------------------------------|----------------|
| 1. Арилжаа явагдсан өдөр                   | 20             |
| 2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/       | 21,941,662,660 |
| Хувьцаа /анхдагч/                          | 18,586,497,300 |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 3,355,165,360  |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 0              |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0              |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 0              |
| 3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг | 34,196,402     |
| Хувьцаа /анхдагч/                          | 10,759,188     |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 23,437,214     |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 0              |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0              |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 0              |
| 4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо              | 5,169          |


## Зах зээлийн үнэлгээ




## TOP-20 индекс



## MSE A индекс



## MSE B индекс



## Бүртгэлтэй хувьцаат компани

|                          |     |
|--------------------------|-----|
| 1. Нийт компанийн тоо    | 198 |
| 100% төрийн өмчит        | 18  |
| Төрийн өмчийн оролцоотой | 10  |
| Хувийн өмчийн            | 171 |
| I ангилал                | 14  |
| II ангилал               | 44  |
| III ангилал              | 140 |

## Гишүүн үнэт цаасны компани

|                                     |    |
|-------------------------------------|----|
| 1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо | 57 |
| Үүнээс: Брокер, Дилер               | 51 |
| Андеррайтер                         | 24 |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх           | 13 |



## Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.06.30-ны байдлаар/

| Симб<br>ол | Нэр                              | Үнэт цаас авсан |                | Үнэт цаас зарсан |                | Арилжааны дүн /авсан,<br>зарсан/ (₮) |
|------------|----------------------------------|-----------------|----------------|------------------|----------------|--------------------------------------|
|            |                                  | Тоо ширхэг      | Үнийн дүн (₮)  | Тоо ширхэг       | Үнийн дүн (₮)  |                                      |
| 1          | Ти Ди Би Капитал ҮЦК             | 1,240,915       | 1,167,792,123  | 11,766,157       | 18,791,686,233 | 39,918,956,712                       |
| 2          | Инвекор капитал ҮЦК              | 9,958,184       | 17,327,016,502 | 6,394            | 11,408,460     | 34,676,849,924                       |
| 3          | Ард секьюритиз ҮЦК               | 5,935,256       | 926,420,447    | 1,544,977        | 253,805,604    | 2,360,452,103                        |
| 4          | Голомт Капитал ҮЦК               | 4,449,829       | 540,488,579    | 1,732,005        | 379,087,321    | 1,839,151,801                        |
| 5          | Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК | 7,296,851       | 456,462,690    | 6,974,462        | 443,203,676    | 1,799,332,731                        |
| 6          | Гаули ҮЦК                        | 928,170         | 334,964,550    | 2,767,096        | 421,708,798    | 1,513,346,697                        |
| 7          | БиДиСек ҮЦК                      | 1,849,039       | 418,043,494    | 1,063,298        | 265,237,615    | 1,366,562,219                        |
| 8          | Стандарт инвестмент ҮЦК          | 754,669         | 271,431,737    | 2,097,825        | 317,633,382    | 1,178,130,237                        |
| 9          | Бумбат-Алтай ҮЦК                 | 832,197         | 164,038,949    | 3,041,888        | 411,707,623    | 1,151,493,146                        |
| 10         | Апекс Капитал ҮЦК                | 182,417         | 135,617,260    | 173,536          | 50,545,731     | 372,325,984                          |
| 11         | Ард капитал групп ҮЦК            | 39,018          | 11,417,137     | 226,444          | 131,703,442    | 286,241,158                          |
| 12         | Лайфтайм инвестмент ҮЦК          | 10,961          | 62,086,190     | 48,452           | 14,787,460     | 153,747,300                          |
| 13         | Гранддевелопмент ҮЦК             | 1               | 6,860          | 709,096          | 72,581,474     | 145,176,668                          |
| 14         | Новел инвестмент ҮЦК             | 57,951          | 18,704,952     | 280,224          | 47,472,566     | 132,355,035                          |
| 15         | Гүүдсек ҮЦК                      | 60,275          | 7,432,210      | 503,674          | 55,849,728     | 126,563,875                          |
| 16         | Батс ҮЦК                         | 1,855           | 1,480,640      | 239,260          | 56,721,997     | 116,405,274                          |
| 17         | Хүннү Эмпайр ҮЦК                 | 5,945           | 2,695,353      | 198,621          | 37,757,055     | 80,904,815                           |
| 18         | Дархан брокер ҮЦК                | 2,587           | 635,032        | 397,970          | 37,396,949     | 76,063,961                           |
| 19         | Зэргэд ҮЦК                       | 100,416         | 10,601,810     | 54,675           | 20,289,676     | 61,782,972                           |
| 20         | Монсек ҮЦК                       | 22,151          | 13,134,550     | 54,687           | 15,847,114     | 57,963,328                           |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.06.30-ны байдлаар/

| №  | Сим-<br>бол | Үнэт цаасны нэр                      | Арилжигдсан<br>ширхэг | Үнийн дүн /₮/ | Дээд Ханш | Доод Ханш | Өөрчлөлт /%<br>/ |
|----|-------------|--------------------------------------|-----------------------|---------------|-----------|-----------|------------------|
| 1  | LEND        | ЛЭНДМН ББСБ                          | 9926772               | 580,168,055.2 | 65        | 57        | 3.13             |
| 2  | AIC         | АРД ДААТГАЛ                          | 723,223               | 482,947,667   | 770       | 599       | 22.12            |
| 3  | ADB         | АРД КРЕДИТ ББСБ                      | 5,503,727             | 417,461,065   | 83        | 65        | 20.37            |
| 4  | INV         | ИНВЕКОР ББСБ                         | 175,707               | 310,345,390   | 1,850     | 1,630     | 12.63            |
| 5  | MFC         | МОНОС ХУНС                           | 4170018               | 297,742,613.1 | 72.4      | 70        | -1.30            |
| 6  | APU         | АПУ                                  | 339,373               | 192,082,022   | 596       | 556       | 1.36             |
| 7  | MNP         | МОНГОЛ ШУУДАН                        | 311756                | 185791720.9   | 700       | 526.01    | 28.90            |
| 8  | MBW         | МОНГОЛ БАЗАЛЫТ                       | 636,195               | 183,328,881   | 294       | 268       | 8.52             |
| 9  | MNDL        | МАНДАЛ ДААТГАЛ                       | 31,314                | 160,427,580   | 5,220     | 5,020     | -1.81            |
| 10 | GOV         | ГОВЬ                                 | 399,306               | 113,981,995   | 298       | 280       | 2.27             |
| 11 | TUM         | ТҮМЭН ШУВУУТ                         | 606,388               | 108,191,687   | 192       | 159       | 10.13            |
| 12 | TTL         | ТАВАН ТОЛГОЙ                         | 14,903                | 104,943,555   | 7,440     | 6,660     | 11.89            |
| 13 | MBG         | МОН-ИТ БУЛИГААР                      | 6,374                 | 48,021,032    | 8,000     | 7,200     | 6.67             |
| 14 | ALI         | СТАНДАРТ НООС                        | 152,624               | 42,734,720    | 280       | 280       | 7.69             |
| 15 | ADU         | ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА                 | 54380                 | 37,109,608.55 | 732       | 665       | -13.94           |
| 16 | ERDN        | ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН | 32,477                | 15,469,926    | 490       | 456       | -2.40            |
| 17 | ITLS        | АЙТҮҮЛС                              | 165,424               | 13,519,819    | 86        | 78        | -3.26            |
| 18 | SUU         | СҮҮ                                  | 69,313                | 13,345,764    | 199       | 185       | -5.16            |
| 19 | BDL         | МОГОЙН ГОЛ                           | 1,132                 | 8,163,400     | 7,500     | 6,600     | -12.00           |
| 20 | SUL         | ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ                    | 59                    | 6,180,500     | 108,500   | 101,300   | 4.58             |



## Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.06.30-ны байдлаар/

| №  | Үнэт цаас нэр       | Арилжигдсан<br>Ширхэг/ | Хаалтын ханш |            | Ханшийн өөрчлөлт /₮/ | Өөрчлөлт %/ |
|----|---------------------|------------------------|--------------|------------|----------------------|-------------|
|    |                     |                        | 2019-06-01   | 2019-06-30 |                      |             |
| 1  | Э-ТРАНС ЛОЖИСТИКС   | 306                    | 83.00        | 132.25     | 49.25                | 59.34       |
| 2  | ХҮННҮ МЕНЕЖМЕНТ     | 6                      | 185.00       | 281.35     | 96.35                | 52.08       |
| 3  | ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ | 422                    | 94.00        | 132.00     | 38.00                | 40.43       |
| 4  | МОНГОЛ ШУУДАН ХК    | 311,756                | 536.20       | 691.16     | 154.96               | 28.90       |
| 5  | МОНГОЛ САВХИ        | 2,264                  | 525.00       | 650.00     | 125.00               | 23.81       |
| 6  | АРД ДААТГАЛ ХК      | 723,223                | 630.00       | 769.35     | 139.35               | 22.12       |
| 7  | АРД КРЕДИТ ББСБ ХК  | 5,503,727              | 67.98        | 81.83      | 13.85                | 20.37       |
| 8  | ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП | 1                      | 170.00       | 195.50     | 25.50                | 15.00       |
| 9  | МОНИНЖБАР           | 596                    | 100.00       | 115.00     | 15.00                | 15.00       |
| 10 | Е-МОНИЕ             | 5                      | 1,287.00     | 1,480.00   | 193.00               | 15.00       |
| 11 | ШИВЭЭ ОВОО          | 193                    | 1,850.00     | 2,104.00   | 254.00               | 13.73       |
| 12 | ИНВЕСКОР ББСБ       | 175,707                | 1,600.00     | 1,802.00   | 202.00               | 12.63       |
| 13 | ГЕРМЕС ЦЕНТР        | 3,229                  | 115.00       | 129.00     | 14.00                | 12.17       |
| 14 | ТАВАН ТОЛГОЙ        | 14,903                 | 6,600.00     | 7,385.00   | 785.00               | 11.89       |
| 15 | ТҮМЭН ШУВУУТ        | 606,388                | 168.56       | 185.63     | 17.07                | 10.13       |
| 16 | МОНГОЛ БАЗАЛТ ХК    | 636,195                | 270.00       | 293.00     | 23.00                | 8.52        |
| 17 | ХАЙ БИ ОЙЛ          | 31,210                 | 50.00        | 54.14      | 4.14                 | 8.28        |
| 18 | ЖЕНКО ТУР БҮРО      | 8,936                  | 66.01        | 71.23      | 5.22                 | 7.91        |
| 19 | СТАНДАРТ НООС       | 152,624                | 260.00       | 280.00     | 20.00                | 7.69        |
| 20 | БИ ДИ СЕК           | 2,154                  | 768.27       | 820.00     | 51.73                | 6.73        |

## Ханшийн бууралттай хувьцаа

/2019.06.30-ны байдлаар/

| №  | Үнэт цаас нэр             | Арилжигдсан /<br>Ширхэг/ | Хаалтын ханш (₮) |            | Ханшийн өөрчлөлт<br>(₮) | Өөрчлөлт % |
|----|---------------------------|--------------------------|------------------|------------|-------------------------|------------|
|    |                           |                          | 2019-06-01       | 2019-06-30 |                         |            |
| 1  | МОНГОЛ ШЕВРО              | 23                       | 2,227.00         | 1,800.00   | -427.00                 | -19.17     |
| 2  | НИЙСЛЭЛ ӨРГӨӨ             | 1                        | 5,900.00         | 5,015.00   | -885.00                 | -15.00     |
| 3  | СИЛИКАТ                   | 300                      | 105.00           | 90.00      | -15.00                  | -14.29     |
| 4  | ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА      | 54,380                   | 783.78           | 674.53     | -109.25                 | -13.94     |
| 5  | ХЭРЛЭН ХИВС               | 7                        | 78.00            | 68.00      | -10.00                  | -12.82     |
| 6  | МОГОЙН ГОЛ                | 1,132                    | 7,500.00         | 6,600.00   | -900.00                 | -12.00     |
| 7  | БИНСЭ ХК                  | 30                       | 340.00           | 300.00     | -40.00                  | -11.76     |
| 8  | СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП | 200                      | 220.00           | 195.00     | -25.00                  | -11.36     |
| 9  | ЦАГААНТОЛГОЙ              | 25                       | 2,100.00         | 1,900.00   | -200.00                 | -9.52      |
| 10 | МОННООС                   | 1                        | 1,981.00         | 1,825.00   | -156.00                 | -7.87      |
| 11 | ТАХЬ-КО                   | 52                       | 11,800.00        | 10,900.00  | -900.00                 | -7.63      |
| 12 | РЕМИКОН                   | 38,125                   | 29.00            | 27.00      | -2.00                   | -6.90      |
| 13 | ДАРХАН НЭХИЙ              | 46                       | 15,000.00        | 14,000.00  | -1,000.00               | -6.67      |
| 14 | БАГАНУУР                  | 864                      | 1,113.00         | 1,040.00   | -73.00                  | -6.56      |
| 15 | АТАР-ӨРГӨӨ                | 1                        | 64,200.00        | 60,000.00  | -4,200.00               | -6.54      |





## ЭНЭТХЭГ УЛСЫН ЭЛЧИН САЙД АРИЛЖАА НЭЭЖ ЦАН ЦОХИЛОО

2019 оны 6 дугаар сарын 27-ний өдөр Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Ноён М.П. Сингх Монголын хөрөнгийн биржид зочилж, 6,004 дэхь удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо. Энэхүү ёслолын арга хэмжээний дараа болсон хөрөнгийн зах зээлийн талаарх танилцуулга уулзалтын үеэр Монголын хөрөнгийн зах зээлд Энэтхэг улсын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, Энэтхэг улсын зүгээс хэрэгжүүлж буй төслүүдийг хөрөнгийн зах зээлийн оролцоотойгоор хэрэгжүүлэх боломж гэх зэрэг олон асуудлаар санал бодлоо солилцож, цаашид идэвхтэй хамтран ажиллах сонирхолтой байгаагаа талууд илэрхийллээ.

## "МОСТ ФИНТЕК" КОМПАНИ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/25 тоот тушаалаар "Мост Финтек" ХХК-ийн нийт 466,716,642 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн III ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 126 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 22.23 хувь буюу 103,766,700 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд МХБ-ийн "Арилжааны журам"-ын дагуу тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө.

Санал болгон худалдах хувьцааны 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдах замаар нийт 4.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Тус компанийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс давсан тохиолдолд нэмж 11.1 хувь буюу 51,649,942 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 47 төгрөгөөр худалдаалахыг зөвшөөрсөн байна.

Энэхүү хувьцааны андеррайтераар "Эс Жи Капитал ҮЦК" ХХК ажиллаж байгаа ба аудитын дүгнэлтийг "Хүлэгт Хүннү Аудит" ХХК, хууль зүйн дүгнэлтийг "Батбаяр энд Партнерс" ХХН, хөрөнгийн үнэлгээг "Координат Аудит" ХХК тус тус үзүүлсэн байна.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУД ЗАХ ЗЭЭЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛААР СЗХ-НД ХҮСЭЛТ ХҮРГҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл болох "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, "Арилжааны төлбөр тооцоо" ХХК, "Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" ӨЗБ хамтран, дотоодын хөрөнгийн зах зээлийг дараагийн шатанд

## Үйл явдал

хүргэж хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар хүсэлтийг 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Энэхүү хүсэлтэнд:

- Хөрөнгө оруулагчдад арилжааны таатай орчин нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдол бүхий төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимд шилжих,
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй боловч арилжааны хөрвөх чадвар сул, дансны болон зах зээлийн үнэлгээ нь хэт зөрүүтэй компаниудын үнэлгээг бодитой болгоход чиглэсэн арга хэмжээ авах,
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлдэг Санхүүгийн зохицуулах хорооны "зохицуулах үйлчилгээний хөлс"-ийг бууруулах эсвэл хөнгөлж мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлуудыг тусгасан байна. Ийнхүү зах зээлд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэснээр, хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ нэмэгдэх, хувьцаат компаниудын хөрвөх чадвар сайжрах, хөрөнгө оруулагчдад ээлтэй арилжааны орчин бий болох, улмаар дотоодын хөрөнгийн зах зээл олон улсын стандартад нийцэж албан ёсны олон улсын зах зээлийн зэрэглэлтэй болоход ихээхэн чухал ач холбогдолтой юм.

## "ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА 2019.06.10-НД ЭХЭЛЛЭЭ

СЗХ-ны даргын 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1/2369 тоот албан тушаалаар "Инвекор ББСБ" ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

## "МОН-НАБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Моннаб" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 19/15 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдуулахаар боллоо.

**Хувьцаа эзэмшигчдийн хуралдах тов:** 2019.07.18-ны өдрийн 14:00 цагт

**Бүртгэх өдөр:** 2019.06.28-ны өдөр

**Хуралдах газар:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Засгийн Газрын 11-р байр 1206 тоот

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох



**Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:**

Хувьцаа эзэмшигчид ажлын өдрүүдэд 09-17 цагийн хооронд “МОННАБ” ХК-ийн байранд ирэх эсвэл хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй холбогдон материалтай танилцах боломжтой.

**Хурал зохион байгуулах комиссын дарга Ш.Оюун-Эрдэнэ; гишүүн Д.Болорцэцэг.**

**Хурал зохион байгуулах комисс: 91919392, 70172141**

## “АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Ард Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн №2/19 тоот тогтоолоор баталсан ногдол ашгийг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн компанийн төв оффис болон Сэнтрал тауэрт байрлах салбараар дамжуулан хүсэлт гаргаснаар өөрийн дансанд хүлээн авах боломжтой болсон бөгөөд хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2019 оны 6-р сарын 28-ны өдрөөс хойш “ҮЦТХТ” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

## “МОНГОЛ БАЗАЛТ” ХК 2018 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА.

“Монгол Базальт” ХК нь ТУЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 4 тоот тогтоолоор 2018 оны цэвэр ашгийн 86% буюу нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгөний ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн 2019 оны 6 сарын 5-ны өдрийн 5 тоот тогтоолын дагуу ногдол ашиг тарах хугацааг урагшуулж 6 дугаар сарын 24-ний өдөр “ҮЦТХТ” ТӨХХК дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан байна.

## "ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА

“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн № А/20 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хурлын тов:** 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт

**Хуралдах газар:** Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д

**Бүртгэлийн өдөр:** 2019 оны 7-р сарын 1-ний өдөр

### Хурлаар хэлэлцэх асуудал:

- 2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
  - Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл харилцдаг үнэт цаасны компани болон Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, 14210, Худалдаа, хөгжлийн банкны төв байранд байрлах “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн байранд ирж танилцаж болно. Холбоо барих утас: 7709 0077

## "ХҮННҮ МЕНЕЖМЕНТ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Хүннү Менежмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн № 6/01 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хурлын тов:** 2019 оны 8-р сарын 05-ны өдрийн 14:00 цагт

**Хуралдах газар:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж Рокмон быулдинг оффис, 404 тоот

**Бүртгэлийн өдөр:** 2019 оны 7-р сарын 10-ны өдөр

### Хурлаар хэлэлцэх асуудал:

- Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах;
  - Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн баталж буйтай холбогдуулан 2019 сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөө батлах;
  - Компанийн дүрмийг өөрчлөн батлах;
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Компанийн өрийг хувьцаанд шилжүүлэх төслийг хэлэлцэж батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл харилцдаг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж Рокмон булдинг оффис, 404 тоотод ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 90991991

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН

---



Монгол Улс, Улаанбаатар  
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN